



**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	8
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар	8
2.8.3	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	11
3.1	Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	13
4.3	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
5	Хавсралт.....	16
	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Б.АВИД ТАНАА

2019.03.25 № 01/558
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шинжлэх ухааны академийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шинжлэх ухааны академийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шинжлэх ухааны академийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Шинжлэх ухааны академийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Шинжлэх ухааны академийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.Авид Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн хөрөнгийн тооллогын үр дүнг баталгаажуулах, баримтжуулах, өр, авлагыг барагдуулах ажил зохион байгуулах талаар зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шинжлэх ухааны академийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинжлэх ухааны академийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 3 дугаар сарын 6-наас 3 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж хариуцаж хэрэгжүүлэв.

Шинжлэх ухааны академийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 4/67 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Шинжлэх ухааны академийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Шинжлэх ухааны академи нь санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Шинжлэх ухааны академи нь шинжлэх ухаан, тэргүүний технологийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны төв байгууллагын хувьд монголын эрдэмтдийн төлөөллийг бүрэн хамарч эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага арга зүйгээр ханган ажилладаг.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл нь:

- Монгол Улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн харилцааны хөгжлийн байдалд шинжлэх ухааны үүднээс дүгнэлт гаргаж, цаашдын чиглэл, арга замыг тодорхойлсон үндэслэл боловсруулах;
- Шинжлэх ухаан, технологийн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлохтой холбогдсон дүгнэлт гаргах;
- Шинжлэх ухаан, технологийн хөтөлбөр, төсөлд үнэлгээ өгөх, хянан магадлагаа хийх;
- Салбарын шинжлэх ухааны хөтөлбөр, чиглэл, түвшинд тогтоосон хугацаанд үнэлгээ, дүгнэлт өгөх;
- Эрдмийн зэрэг цолтой боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх;

Дээрх зорилтын хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, Шинжлэх ухааны академийн эрхзүйн байдлын тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль,

Засгийн газрын тогтоолоор батлагдсан Шинжлэх ухааны академийн дүрэм болон бусад хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, салбарын болон хувийн секторын эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулиудтай хамтран ажиллаж байна.

Шинжлэх ухааны академийн харьяанд Газарзүй, гео-экологи, Ерөнхий болон сорилын биологи, Одон орон, геофизик, Олон улсын харилцаа, Түүх, археологи, Палеонтологи, геологи, Физик, технологи, Философи, Хими, химийн технологи, Хэл зохиол зэрэг нийт 10 хүрээлэн 1085 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Шинжлэх ухааны академийн удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Шинжлэх ухааны академийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Шинжлэх ухааны академийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Шинжлэх ухааны академийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Э-тайлан” програм хангамж ашигладаг байна.

Шинжлэх ухааны академийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Шинжлэх ухааны академийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад

дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Нийт болон цэвэр хөрөнгө харьцангуй тогтмол үзүүлэлт, орлогын 79.5 хувийг улсын төсвийн санхүүжилт бүрдүүлдэг ба үйл ажиллагааны зардлын дүнгээс тооцох нь илүү бодитой, ажил гүйлгээний төрлийн эрсдэл, төлөвлөлтөөс хэтрэх, үр ашиггүй зардал гаргах зэрэг эрсдэлд өртөмтгий байх магадлалыг харгалзан нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг Шинжлэх ухааны академийн 2018 оны 2 дугаар улирлын Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал дээр сүүлийн хагас жилийн үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөг нэмж хүлээгдэж байгаа гүйцэтгэл 15,719.2 сая төгрөгийн 2 хувь буюу 314.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлээр төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшин 63.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 2018 оны жилийн эцсээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал 18,913.7 сая төгрөгт хүрч, хүлээгдэж буй гүйцэтгэлээс 3,194.5 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтийн 2 хувиар тооцсон нь шинж чанар болон орчин нөхцлийн хувьд материаллаг шинжтэй зүйлс илрээгүй ба эрсдэл дунд гэж үзсэн болно.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 11 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдэхээс харьяа 10 хүрээлэнгийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газрын захиалгаар аудитын компаниуд аудит хийж, тэргүүлэгчдийн газрыг аудитын түүвэрт хамруулсан болно.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	ТШЗ	10	1		
	ДҮН	10	1		

Харьяа 10 хүрээлэнгийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газрын захиалгаар аудитын компаниуд аудит хийж, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Шинжлэх ухааны академийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 14,789.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 97.8 хувь буюу 14,466.1 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 4.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 0.1 хувь буюу 16.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 2.0 хувь буюу 303.4 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлээ.

Аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 3,910.3 сая төгрөг, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэлээр 10,555.8 сая төгрөгийн алдааг залруулсан болно.

Шинжлэх ухааны академийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

(сая төгрөг)

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	22	192.7	2	4.0	1	16.3	19	172.4				
2	ТТЗ	2	131.0					2	131.0				
	Дүн	24	323.7	2	4.0	1	16.3	21	303.4				

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн материаллаг хэмжээний, анхаарал татахуйц алдаа зөрчилтэй асуудлыг тоймлоход:

- Физик, технологийн хүрээлэн тайлант онд 191.9 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авч 96.5 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээний төлбөрийн е баримт аваагүй,
- Одон орон, геофизикийн хүрээлэн байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой 24.1 сая төгрөгийн өндөр үнэтэй бараа материалын зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй,
- Гео-экологийн хүрээлэн ХХОАТ 10.3 сая, урьдчилж гарсан зардал 6.0 сая төгрөгийг бүртгээгүйгээс санхүүгийн байдал, үр дүнгийн тайлан алдаатай илэрхийлэгдсэн,

- Хими, хими технологийн хүрээлэн тендер зарлаагүйгээр 14.1 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан,
- Ерөнхий ба сорилын биологийн хүрээлэн 12.3 сая төгрөгийн тавилга эд хогшилд компьютер ба түүний дагалдах хэрэгслийн ангиллыг буруу бүртгэсэн,
- Палеонтологи, геологийн хүрээлэн шатахуун, гадаад томилолттой холбоотой үүссэн 10.7 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардал дансны зарим гүйлгээг 5-6 сарын дараа хаасан зэрэг зөрчилтэй байна.

2.8.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Шинжлэх ухааны академи 3 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан 14,154.2 сая төгрөгийн төсөв зарцуулах, үүний 13,931.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 222.4 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын төсвөөс 13,856.1 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, төлөвлөгөөнөөс 75.7 сая төгрөг дутуу байна. Үндсэн үйл ажиллагааны орлого 6.9 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 6.4 сая төгрөг, нийт 13.3 сая төгрөгөөр төсөвт байгууллагын орлогын төлөвлөгөөг давуулжээ.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 14,091.3 сая төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 27.2 сая төгрөг, цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 21.9 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 5.3 сая төгрөг, томилолт, зочны зардал 3.1 сая төгрөг, урсгал шилжүүлэг 3.0

сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1.8 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 0.5 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 0.1 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал 0.1 сая төгрөг, нийт зардлыг 63.0 сая төгрөгөөр хэмнэснээс шалтгаалжээ.

Нэмэлт төсвийн санхүүжилтийн орлого 4,859.4 сая төгрөг төвлөрүүлж, 4,049.5 сая төгрөгийг зарцуулж, 803.8 сая төгрөгийг татаас, санхүүжилтийн авлага үүсгэж, үлдэх 6.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Шинжлэх ухааны академи Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шинжлэх ухааны академи нь Шилэн дансны хуульд заасан дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Байгууллагын цахим хуудас www.mas.mn сайтад шилэн дансны цэсийг холбосон. Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан. 5 сая төгрөгөөс доош үнийн дүн бүхий бараа, ажил үйлчилгээний тушаал, шийдвэрүүдийг оруулсан байна. Жилийн эцэс, хагас жилийн санхүүгийн тайланг оруулсан байна. Тайланг хугацаанд нийт 965 мэдээлэл оруулахаас 932 мэдээллийг хугацаанд нь оруулж баталгаажуулан 29 мэдээллийг хугацаа хоцроосон, 4 мэдээлэл оруулаагүй байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгө, авлага, өглөг, санхүүгийн тайлагналын талаар 3 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн биелүүлсэн байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шинжлэх ухааны академийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шинжлэх ухааны академийн 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Шинжлэх ухааны академийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүд үндсэн хөрөнгө болон бараа материалын жилийн эцсийн тооллогын тооцоог бодож, үр дүнг баталгаажуулдаггүй дутагдал илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдэх, хөрөнгө үрэгдэх, шамшигдах

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж, хөрөнгийн тооллогыг чанартай сайн гүйцэтгэж, үр дүнг шийдвэрлэж, үлдэгдлийг баталгаажуулан, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлж ажиллана.

3.2 Өр, авлагатай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Тайлант оны эцэст авлага 908.0 сая, урьдчилж төлсөн зардал 56.0 сая, өглөг 17.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс татаас санхүүжилтийн авлага 599.2 сая, бусад авлага 91.4 сая, урьдчилж төлсөн зардал 33.0 сая, өглөг 3.3 сая төгрөгийн он дамжсан авлага, өр төлбөрийн үлдэгдэлтэйгээс 3.3 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 1.8-д “ өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Авлага, урьдчилж төлсөн зардал, өглөгийн үлдэгдэл буруу илэрхийгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлж, ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	2,598.8	3,585.5
Авлага	1,164,004.2	907,950.8
Урьдчилж төлсөн зардал	190,819.9	33,018.9
Бараа материал	1,335,625.0	974,180.3
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,693,047.9	1,918,735.5
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
Үндсэн хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	13,000,788.2	24,600,719.4
Биет бус хөрөнгө	441,969.4	6,106,082.1
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	13,442,757.6	30,706,801.5
ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН	16,135,805.4	32,625,537.0
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Өглөг	46,448.5	20,713.4
Богино хугацаат өр төлбөрийн дүн	46,448.5	20,713.4
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	46,448.5	20,713.4
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ		
Засгийн газрын хувь оролцоо	16,089,356.9	32,604,823.6
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	16,089,356.9	32,604,823.6
ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН НИЙТ ДҮН	16,135,805.4	32,625,537.0

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
Татварын бус орлого	1,505,058.4	1,103,724.2
Тусламж, санхүүжилтийн орлого	16,559,583.2	17,809,960.9
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН НИЙТ ДҮН	18,064,641.6	18,913,685.1
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
УРСГАЛ ЗАРДАЛ		
Цалин хөлс болон ажиллагсдын тэтгэмж	10,532,770.4	11,067,595.4
Татаас болон шилжүүлгийн төлбөр	98,770.9	92,785.5
Бараа, үйлчилгээний зардал	351,672.5	361,402.9
Нийгмийн хамгааллын зардал	374,595.9	130,643.5
Элэгдэл, хорогдлын зардал	1,285,397.4	1,413,685.4
Үндсэн үйл ажиллагааны бусад зардал	5,192,832.1	6,446,480.4
Үндсэн үйл ажиллагааны зардлын нийт дүн	17,836,039.2	19,512,592.8
Үндсэн үйл ажиллагааны нийт ашиг/(алдагдал)	228,602.4	(598,907.7)
Үндсэн хөрөнгө борлуулсны олз (гарз)	12,531.1	557,973.4
Үндсэн бус үйл ажиллагааны орлого (зардал)-ын нийт дүн	12,531.1	557,973.4
Тайлант үеийн цэвэр ашиг/(алдагдал)	216,071.3	(1,156,881.1)

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Хүлээн авсан мөнгөн хөрөнгө:		
Татварын бус орлого	1,127,498.6	252,480.7
Тусламж, санхүүжилтийн орлого	16,579,589.8	18,791,179.7
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын нийт дүн	17,707,088.4	19,043,660.4
Зарцуулсан мөнгөн хөрөнгө:		
Цалин хөлс болон ажиллагсдын тэтгэмж	10,647,349.4	11,030,614.2
Татаас болон шилжүүлгийн төлбөр	1,084,414.3	896,777.7
Бараа, үйлчилгээний зардал	289,085.5	288,057.6
Нийгмийн хамгааллын зардал	374,595.9	130,643.5
Үйл ажиллагааны бусад зардал	4,933,269.7	6,134,877.7
Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн хөрөнгийн нийт дүн	17,328,714.8	18,480,970.7
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	378,373.6	562,689.7
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Зарцуулсан мөнгөн хөрөнгө:		
Биет болон биет бус үндсэн хөрөнгө худалдан авалт	378,761.6	561,703.0
Хөрөнгө оруулалт цэвэр мөнгөн гүйлгээ	(378,761.6)	(561,703.0)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)	(388.0)	986.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,986.8	2,598.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,598.8	3,585.5

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,874,242.3	-	15,874,242.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	64,998.7	-	64,998.7
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,939,241.0	-	15,939,241.0
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн үр дүн	(65,955.4)	-	(65,955.4)
Тайлант үеийн үр дүн /цэвэр ашиг/алдагдал	216,071.3	-	216,071.3
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,089,356.9	-	16,089,356.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	(18,268.1)	-	(18,268.1)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,071,088.8	-	16,071,088.8
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн үр дүн	11,964,171.0	-	11,964,171.0
Өмчид гарсан өөрчлөлт	5,726,444.9	-	5,726,444.9
Тайлант үеийн үр дүн /цэвэр ашиг/алдагдал	(1,156,881.1)	-	(1,156,881.1)
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	32,604,823.6	-	32,604,823.6

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		5.6	5.6	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,154,278.1	14,091,291.7	(62,986.4)	99.6
УРСГАЛ ЗАРДАЛ	14,154,278.1	14,091,291.7	(62,986.4)	99.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,016,493.3	13,956,517.2	(59,976.1)	99.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,509,399.0	10,487,469.4	(21,929.6)	99.8
Үндсэн цалин	9,298,253.8	9,521,892.0	223,638.2	102.4
Нэмэгдэл	813,202.1	645,717.1	(167,485.0)	79.4
Унаа хоолны хөнгөлөлт	341,997.6	274,649.1	(67,348.5)	80.3
Урамшуулал	55,945.5	45,211.2	(10,734.3)	80.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,258,735.5	1,231,578.2	(27,157.3)	97.8
Тэтгэврийн даатгал	837,882.6	893,805.8	55,923.2	106.7
Тэтгэмжийн даатгал	105,213.3	95,131.0	(10,082.3)	90.4
ҮОМШӨ-ний даатгал	84,170.5	81,143.2	(3,027.3)	96.4
Ажилгүйдлийн даатгал	21,042.4	15,993.0	(5,049.4)	76.0
Эрүүл мэндийн даатгал	210,426.7	145,505.2	(64,921.5)	69.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	520,372.7	518,609.9	(1,762.8)	99.7
Гэрэл, цахилгаан	260,766.2	251,837.9	(8,928.3)	96.6
Түлш, халаалт	187,734.3	195,391.8	7,657.5	104.1
Цэвэр, бохир ус	39,838.2	39,346.1	(492.1)	98.8
Байрны түрээс	32,034.0	32,034.0	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	230,033.5	229,910.9	(122.6)	99.9
Бичиг хэрэг	23,950.2	30,296.4	6,346.2	126.5
Тээвэр, шатахуун	21,720.5	16,482.5	(5,238.0)	75.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	44,507.3	35,838.3	(8,669.0)	80.5
Ном, хэвлэл	96,769.9	95,347.8	(1,422.1)	98.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,239.6	10,434.6	195.0	101.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,846.0	41,511.3	8,665.3	126.4
Нормативт зардал	2,580.0	2,580.0	-	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,580.0	2,580.0	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	446,647.4	446,517.6	(129.8)	100.0
Багаж, техник, хэрэгсэл	181,040.1	181,397.9	357.8	100.2
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000.0	3,296.0	296.0	109.9
Урсгал засвар	262,607.3	261,823.7	(783.6)	99.7
Томилолт, зочны зардал	136,607.2	133,529.2	(3,078.0)	97.7
Гадаад албан томилолт	-	7,524.5	7,524.5	
Дотоод албан томилолт	136,607.2	126,004.7	(10,602.5)	92.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	836,181.1	830,919.0	(5,262.1)	99.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	802,151.6	799,170.5	(2,981.1)	99.6
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	19,980.0	19,480.0	(500.0)	97.5
Даатгалын үйлчилгээ	3,204.5	2,100.7	(1,103.8)	65.6
Тээврийн хэрэгслийн татвар	1,853.2	1,747.9	(105.3)	94.3
Тээврийн хэрэгслийн оношлогоо	437.5	247.5	(190.0)	56.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500.0	1,500.0	-	100.0
Газрын төлбөр	6,934.3	6,672.4	(261.9)	96.2
Бараа үйлчилгээний бусад зардал	75,936.9	75,403.1	(533.8)	99.3
Бараа үйлчилгээний бусад зардал	14,460.4	14,181.9	(278.5)	98.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	61,476.5	61,221.2	(255.3)	99.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	137,784.8	134,774.5	(3,010.3)	97.8
Засгийн газрын урсгал шилжүүлэг	7,745.0	5,602.2	(2,142.8)	72.3
Засгийн газрын гадаад шилжүүлэг	7,745.0	5,602.2	(2,142.8)	72.3
Бусад урсгал шилжүүлэг	130,039.8	129,172.4	(867.4)	99.3
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	27,908.6	27,866.0	(42.6)	99.8
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	102,131.2	101,306.4	(824.8)	99.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,154,158.1	14,091,786.1	(62,372.0)	99.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	13,931,793.1	13,856,104.3	(75,688.8)	99.5

Шинжлэх ухааны академийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Улсын төсвөөс санхүүжих	13,931,793.1	13,856,104.3	(75,688.8)	99.5
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	222,365.0	235,681.9	13,316.9	106.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	156,425.0	163,340.1	6,915.1	104.4
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,940.0	72,341.8	6,401.8	109.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	500.0	500.0	
Төсвийн байгууллага	11	11	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	1186	1181	(5.0)	99.6
Удирдах ажилтан	68	72	4.0	105.9
Гүйцэтгэх ажилтан	924	916	(8.0)	99.1
Үйлчлэх ажилтан	194	193	(1.0)	99.5

5 Хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2018 он

Аудитын нэр:

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит

Аудитын код:

САГ-2019/20/СТА-ТТЗ

Шалгагдсан байгууллагын нэр

Шинжлэх ухааны академи

сая төгрөгөөр

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
						Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	9	10
1	Үндсэн хөрөнгийн тооллого	1	Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүд үндсэн хөрөнгө болон бараа материалын жилийн эцсийн тооллогын тооцоог бодож, үр дүнг баталгаажуулдаггүй дутагдал илэрлээ.	-	Зөвлөмж	Эрдэмтэн нарийн бичгийн дарга	Б.Авид
						Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга	А.Баярбаатар
2	Авлага, урьдчилж төлсөн зардал, өглөг	1	Тайлант оны эцэст авлага 908.0 сая, урьдчилж төлсөн зардал 56.0 сая, өглөг 17.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс татаас санхүүжилтийн авлага 599.2 сая, бусад авлага 91.4 сая, урьдчилж төлсөн зардал 33.0 сая, өглөг 3.3 сая төгрөгийн он дамжсан авлага, ер төлбөрийн үлдэгдэлтэйгээс 3.3 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	131.0	Зөвлөмж	Эрдэмтэн нарийн бичгийн дарга	Б.Авид
						Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга	А.Баярбаатар



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, spanning the width of the page.



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.